



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrtд.gov.mn, http://www.mrtд.gov.mn

2023-03-15 № 01/117
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦЭНГЭЛ ТАНАА

Үнэлгээ хүргүүлэх тухай

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” (ХХНОБ) ТӨХХК-ийн захирлын 2022 оны гэрээний биелэлтийг дүгнэхтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 3.11-д заасны дагуу салбарын яамнаас өгөх үнэлгээг хүргүүлж байна.

“ХХНОБ” ТӨХХК-ийн 2022 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 83,0%-тай буюу 20,7 оноогоор үнэлэгдлээ.

Хавсралт 6 хуудастай.



С.БЯМБАЦОГТ

080000396



**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-Д
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, САЙДЫН ТУШААЛААР ӨГСӨН ҮҮРЭГ
ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2023.01.13

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” /ХХНОБ/ ТӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“ХХНОБ” ТӨХХК-ийн 2022 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **83,0%**-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

| Нийт заалт | Үүнээс | | | | | Биелэлтийн хувь |
|------------|--------|----------|----------|----|------------------|-----------------|
| | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| 4 | - | 2 | 1 | - | 1 | 56,7% |

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ Засгийн газрын албан даалгавар. 2022 №01

9.1 “Чингис хаан” ОУНБ-ыг олон улсын агаарын ачаа тээврийн транзит төв болгон өргөжүүлэх саналыг төсөл хэрэгжүүлэгч талд тавьж шийдвэрлүүлэх

Биелэлт: *Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд СЯ, ЭЗХЯ, ЗТХЯ-аас 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Монголын Эдийн засгийн чуулган-2022” зохион байгуулсан урьдчилсан “Боомтын шинэчлэл”, “Эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтын хөгжлийн асуудал”, “Хилийн боомтуудыг дэд бүтцээр холбох, тээврийн коридоруудын үр ашгийг дээшлүүлэх нь”, “Иргэний нисэхийн салбарын шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт хэлэлцүүлэгт компанийн гүйцэтгэх удирдлагаас төлөөлөл оролцсон.*



ЗТХ-ийн сайд Л.Халтар, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Китанака Такефуми, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Цэнгүүнжав нар “Чингис хаан олон улсын нисэх буудал”-ын үйлчилгээг сайжруулах талаар санал солилцох уулзалт хурлыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа.

“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн зүгээс “Чингис хаан олон улсын нисэх буудал”-ын үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний чанарыг дэлхийн түвшинд хүргэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, Япон улсад хэрэгжиж буй үйлчилгээний соёлыг шинэ нисэх буудалд дэлгэрүүлэх зорилго бүхий “Нисэх буудлын үйлчилгээг сайжруулах ажлын төлөвлөгөө”, “Олон улсын явах нислэгийн зорчигч урсгалын бөөгнөрлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус гарган ажиллаж байна.

ХЗДХ-ийн сайдаас “Агаарын замын “Чингис хаан” хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөл”-д санал авах тухай 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 1/2840 дугаар албан бичгийг ЗТХ-ийн сайдад ирүүлсэн бөгөөд уг тогтоолын төсөлд “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн зүгээс тусгуулах холбогдох саналыг Зам, тээврийн хөгжлийн яаманд цахимаар хүргүүлэв.

ЗТХ-ийн сайд С.Бямбацогтод ИНЕГ-ын дарга С.Мөнхнасан, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Цэнгүүнжав, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Китанака Такефуми нар 2022 оны 09 дүгээр сарын 20, 10 дугаар сарын 12-ны өдөр “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа, зорчигчдын бөөгнөрөл, тулгамдаж буй асуудлыг газар дээр нь танилцуулж, үүрэг, чиглэл аван ажилласан.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооноос 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан Засгийн газрын 2022 оны 371 дүгээр тогтоолоор байгуулагдсан Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны гишүүд, холбогдох бусад байгууллагын төлөөллийн уулзалтад “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн удирдлага оролцож, “Чингис хаан” олон улсын нисэх буудлын ашиглалтын байдал, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар танилцуулга хийв.

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын нутаг дэвсгэрт баригдах 600 айлын орон сууц барих төсөл, буухиа автобус, Кэмпийн барилгыг ашиглалт, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйлчилгээний талаар эдийн засаг, санхүү, үр ашгийн тооцоо судалгааг хийж Хувьцаа эзэмшигч нарыг мэдээллээр ханган ажилласан. Концессын гэрээний 19-р зүйлийн дагуу “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Концессын 15 жилийн хугацаа буюу 2035 он хүртэлх хугацааны Мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг төсвийн хамтарсан компанийн ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулах, мастер төлөвлөгөөг 2023 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн. 30%

2.2.Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

| Нийт заалт | Үүнээс | | | | | Хүчингүй болсон | Биелэлтийн хувь |
|------------|--------|-----|-----|----|------------------|-----------------|-----------------|
| | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | | |
| 22 | 19 | 1 | - | - | 2 | - | 98,5% |



Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай 2020.08.21 №160

1. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг 2021.01.01-ний өдрөөс тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.

Биелэлт: Энэ ажлын хүрээнд "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем", "Outlook2021", "ABLE" программыг үйл ажиллагаандаа ашиглаж, 2022 оны 05 дугаар сарын эхний улирлын байдлаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас "ABLE" программаар 8 албан бичгийг хүлээн авч, 19 албан бичгийг хүргүүлж, компанийн ажилтан нар дотооддоо "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-ээр 41 албан бичгийг солилцон, үйл ажиллагааны шуурхай байдлыг ханган ажиллалаа. Үүнээс 18 албан бичгийг цахим тоон гарын үсэг ашиглан Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэв. 70%

2.3. Шилэн дансны үнэлгээ:

| Мэдээлэл | Нийт заалт | Үүнээс | | | | | Биелэлтийн хувь |
|--|------------|----------|----------|----------|----------|------------------|-----------------|
| | | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| Төсөв/гүйцэтгэл | 1 | 1 | - | - | - | - | 100,0 |
| хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт | 3 | 3 | - | - | - | - | 100,0 |
| бусад | 3 | 3 | - | - | - | - | 100,0 |
| Нийт | 7 | 7 | - | - | - | - | 100,0 |

2.4. Ил тод байдлын үнэлгээ:

| Мэдээлэл | Нийт заалт | Үүнээс | | | | | Биелэлтийн хувь |
|---|------------|-----------|----------|----------|----------|------------------|-----------------|
| | | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл | 8 | 2 | 4 | 1 | 1 | - | 63,7 |
| Хүний нөөцийн мэдээлэл | 6 | 4 | 1 | 1 | - | - | 83,3 |
| Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл | 12 | 8 | - | 1 | - | 3 | 92,2 |
| Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл | 1 | - | 1 | - | - | - | 70,0 |
| Бусад мэдээлэл | 1 | 1 | - | 1 | - | - | 65,0 |
| Нийт | 28 | 15 | 6 | 4 | 1 | 3 | 81,6 |

Бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ 1.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ /30%/



- 2/ 1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл /0%/
- 3/ 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам /30%/
- 4/ 3.15. Хууль тогтоомжид заасан бусад /30%/
- 5/ 5.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшуулалын дүн, албан цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл /30%/

Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай контрактын гэрээ байгуулахаас гадна компанийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын яамтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажлаа дүгнүүлдэг байх зохицуулалтыг бий болгох зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

2. Хэрэгжилтийн байдал:

"ХХНОБ" ТӨХХК-ийн 2021 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **83,0%**-тай байна.

Санал, зөвлөмж

- 2023 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Чингис хаан" ОУНБ-ыг олон улсын агаарын ачаа тээврийн транзит төв болгон өргөжүүлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлууд тусган ажиллах;
- Байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах ажлыг тогтмол зохион байгуулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтэд тусгасан мэдээллүүдийг вэб хуудсандаа тогтоосон хугацаанд тогтмол байрлуулах;
- Холбогдох тайлан, мэдээллийг ЗТХЯ-д хугацаанд нь тодорхой тоо баримттай бүрэн ирүүлж байх;

ТАНИЛЦСАН:

САЙД

ДЭД САЙД

С.БЯМБАЦОГТ

Л.ХАЛТАР



ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ИНБХЗГ-ЫН ДАРГА

Ч.МӨНХТУЯА

ХХНОБ ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л.ЦЭНГҮҮНЖАВ

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА

А.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Д.БАЯРМАА



**ХХНОБ ТӨХХК-Д ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР,
САЙД ТУШААЛААР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ,
ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН БАЙДАЛ**

2023.01.13

| № | Хяналтанд байх арга хэмжээ | 2022 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ | | | | | Хугацаа болоогүй |
|-------------|--|--------------------------------------|---|------------------|-----------|----------|----------|----------|------------------|
| | | | | Дундаж хувь | 100 | 70 | 30 | 0 | |
| 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт | 4 | 3 | 56,7 | - | 2 | 1 | - | 1 |
| 2 | Сайдын тушаалын биелэлт | 22 | 20 | 98,5 | 19 | 1 | - | - | 2 |
| 3 | Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ | 13 | 13 | 100,0 | 13 | - | - | - | - |
| 4 | Ил тод байдлын үнэлгээ | 32 | 29 | 78,5 | 15 | 6 | 4 | 1 | 3 |
| Нийт | | 72 | 66 | 83,0 | 47 | 9 | 5 | 1 | 6 |